

ДИПЛОМАТ ЁС ГОРИМ ТӨРИЙН ЁСЛОЛЫН УЛАМЖЛАЛ, ШИНЭЧЛЭЛИЙН ЗАРИМ АСУУДАЛ

Д.Цолмон*

Аливаа улсын дипломат ёс горим, ёслол бол тухайн улсын гадаад харилцааны хөгжил, зан заншилтай холбоотой түүхэн ойлголт мөн. Ёс горим нь нийгмийн байгуулал, уламжлал, эдийн засаг, цэрэг зэвсгийн хүчин чадал, улсын нэр хүндтэй ч холбогдоно. Монголын дипломат ёс горим нүүдэлчдийн соёл иргэншил, эртний болон эзэнт гүрний монголчуудын гадаад ертөнцтэй харилцаж ирсэн түүхэн онцлогийг илтгэн харуулж байна.

Монголчууд эртнээс ёс горимгүй, төрийн бодлогогүй, бүдүүлэг үндэстэн байгаагүй. Ёс жаягтай эртний үндэстэн гэдгийг Монголын болон гадаадын цөөн биш судлаач бүтээлдээ тусгасан байдаг. Тэгэхдээ Монголын Их эзэнт гүрэн, түүний дараачийн хаадын үеийн гадаад бодлого, ёс жаягийг өнөөгийн нөхцөлд авч үзэхдээ бодитой бөгөөд хүн төрөлхтний хөгжлийн эдүгээ цагийн чиг хандлагын үүднээс хандах учиртай юм. Олон улсын харилцаа, эрх зүйн хэм хэмжээний аль аль нь уламжлал, заншилтай холбоотой байдаг. Зан заншлын нөлөө улбаа яван явсаар эрх зүйн хэм хэмжээ болох тохиолдол ч бий. Дипломат элчийн бүрэн эрх, халдашгүй дархан эрхийн элементүүд дундад эртний улсууд, тухайлбал Монголын хаадын гадаад улс гүрэнтэй харилцахдаа мөрддөг асан ёс заншлын тухай бичсэн сурвалжуудад элбэг тохиолддог юм.

Хааны элчийн халдашгүй дархан эрхийг хамгаалах, түүнийг хүндэтгэх нь эзэн хаан, түүний төр, сүр хүчийг хүндэтгэж буй хэрэг хэмээн үзэж байжээ. Монгол элчис түргэн хүргэх зар мэдээ, тамга тэмдэг, бичээч хэлмэрчтэй байж хэл нэвтэрч харилцан ойлголцож байсан ажээ.

Дипломат зар бичгийн өөрөөр хэлбэл дипломат жуух бичгийн эртний хэлбэр болох алт, мөнгө, хүрэл, модон пайз Гэрэгэ Монголын эзэнт гүрний “Зарлигийн элч” нарт олгож байсан нь тэрхүү элчийн зэрэг дэвийг тодорхойлохын зэрэгцээ түүнийг саадгүй

* МУИС, ОУХС-ийн тэргүүлэх профессор, доктор (Ph.D)

өнгөрүүлэх, зорьсон хэргээ бүтээхэд нь дэм, хүндэтгэл үзүүлэх агуулгатай байлаа. Монголын түүх, гадаад элчин төлөөлөгчдийн тухай Рашид-ад Дин, Плано Карпини, Рубрук болон Герман, Англи, Франц, Америкийн орчин үеийн Монголын судлаачдын олон бүтээл нотолж байна.

1219 онд Хорезмийг довтлохоос өмнө Чингис хаан Хорезмийн Шах Мухамедэд элч зарж хоёр гүрэн харилцаатай болж арилжаа наймаа хийх, энх амгалан зэрэгцэн аж төрөх эрмэлзлээ илэрхийлэхэд худалдаачин 450 хүнийг алж, дараа нь илгээсэн Багрич тэргүүтэй элчисийн амь насанд халдаж заримыг нь доромжлон буцаахад Чингис хаан “ёс журмаас тэрсэлсэн” гэж хилэгнэн дайн зарлаад цэргээ өөрөө толгойлон мордсон нь эв эеийг хичээх аргаас цэрэг зэвсгийн хүчээр тэрхүү дайсагнасан гүрнийг номхотгож хил хязгаар, аюулгүй байдлаа хамгаалах, эзэнт гүрнийхээ нөлөөг өргөтгөх газар зүйн ашиг сонирхолтой холбоотой дайн болжээ.

Их Монгол улс байгуулагдаад Хорезмтэй арилжаа наймаа хийж энх тайван оршихыг хүсэж байснаас бус шууд дайн үүсгэхийг ер санаж байсангүй гэж Өвөрлөгч судлаач Сайшаалт¹ агсан “Чингис хааны товчоон” хэмээх бүтээлдээ голч дүгнэлт өгчээ.

Чингисийн үед ч, түүний дараах хаадын үед ч гадаад гүрнээс ирсэн элч нарыг найр тавин угтаж өндөр хүндэтгэл үзүүлж байсан юм. Энэ тухай Д.Оссоны² “Монголчуудын түүх” хэмээх бүтээлд бий. Монгол хаадад гаднын элчин төлөөлөгчид олноор хүрэлцэн ирж бараалхаж байсан учир элч нарыг хүлээн авах өвөрмөц ёс журам хаадын өргөөний дотор мөн бий болж байжээ хэмээгээд гаднаас ирсэн элчийг өртөө буудлын тусгай алба хүлээн авдаг, ямар хэргээр явааг нь асуудаг, элч нарыг нэгжин үзэж хоёр галын хоорондуур гаргадаг зэрэг ёс горимын тухай Плано Карпиний зохиолд бий. Өрнө зүгийн нэг элчинг галын дундуур оруулж ирэх ёсыг дагаагүй учир хүлээж авалгүй буцаасан байдаг.³

Галын хоорондуур гаргадаг нь эртний бөө мөргөлтэй холбоотой бузрыг арилган ариутгах утгатай, өнө эртний улбаатай бүлгээ. Элчин нар хаанд зүүн өвдгөө нугалан сөхөрч, хөрөгт нь мөргөдөг, ирсэн гийчнийг хаан, ордныхонд өндөр дуугаар сонсгон илтгэдэг зэрэг ёс, эсвэл элчийн ярих айлтгалыг урьдчилан хэлүүлж их хаанд илтгэдэг зэрэг нь өвөрмөц ёслол, ёс горимын чанартай хүндэтгэл ба бас төрийн тэргүүн эзэн хаанаа, улс гүрнээ хүндэтгэж байсны илрэл мөн.

¹ Сайшаалт, “Чингис хааны товчоон”, Хөх хот, 1987 он.

² Д.Оссон, “Монголчуудын түүх”, 1-р боть, 127 дахь талд

³ Д.Хүүхэнбаатар, “Монгол гүрний элчин харилцаа”, УБ 1964 он, 13 дахь талд

Элчийг сонгохдоо гадаад улс гүрэн, алс хол яваа эзэд ноёдод зар хүргэх буухиа шуудан нарийн зохион байгуулалттай, хөтөлгөө морьтой, нэгэн өртөөнөөс нөгөөд хэл хүргэх хамгийн шилдэг эрчүүд, сайн мориор явж замдаа тохиолдсон ямар ч саад бэрхшээлийг давж байсан тухай түүхэнд өгүүлнэ. Улсын нийслэлээс гарсан элч Өгөөдэй хаан насан эцэслэсэн (1242) мэдээг Балканы хойгт долоо хоногийн дотор Бат хаанд хүргэсэн нь орчин үеийн хүнд ойлгож ухаарахад ч хэцүү юм.

Монголын түүхийн сурвалж бичгүүдэд адуун сүргийн цэрэг, улс төрийн ач холбогдолын тухай нүүдэлчин монголчууд байлдах, өртөө, улаа нэхэхэд адуугүйгээр боломжгүй тухай Плато Карпини, В. Рубрук, Рашид-ад Дин зэрэг олон хүний тэмдэглэлд онцлон тэмдэглэсэн байдаг юм. Монголчуудын нүүдлийн амьдралд адуун сүргийн гүйцэтгэх үүрэг өндөр байсныг ч цөөн биш судлаачийн бүтээлд байдаг.

“Рашид -ад Дин монголчууд хэрэв мориноосоо салбал юуныг ч үл хийж чаднам гэж тэдний дайснууд хэлэлцдэг” гэсэн ба Нууц товчоон, билиг сургаал зэрэгт Чингис хаан “Хэрэв мориноос ойчих ахул тэр хэрхэн байлдан тулалдаж чадах вэ гэж хэлсэн зэрэг үгс тохиолдоно.”⁴

Эзэн хаад элч зарахдаа шүлэглэсэн дуу бариулж, хэлэх дамжуулах утга санааг алдалгүй ёсоор нь хүргэхэд нууцыг чандлан сахих нэн өвөрмөц арга хэрэглэж байлаа. Эртний нүүдэлчдийн билиг ёсон, аман зохиол нь ийнхүү улс гүрний элчийн хэрэглүүр болсон нь нэгэн онцлог мөн. Энэ тухай Монголын нэрт эрдэмтэн Цэндийн Дамдинсүрэн асан аман зохиол, “албан бичиг нь их төлөв шүлэг бөгөөд цээжлэвч амархан тул дуу гэж нэрлэсэн мэт” хэмээн Нууц товчооны судлалдаа тэмдэглэсэн юм⁵

Түүхч Рашид-ад Дин Монгол хаадын элчдээ “толгой голдуу холбон шүлэглэсэн ёгт уран үгийг цээжээр хэлж дамжуулдаг заншилтай байсан” юм гэжээ.⁶ Энэхүү ёсон эхлээд бэр гуйх, гэр барихад ерөөл магтаалын хэлбэртэй байгаад сүүлдээ хаад ноёд, улс хоорондын харилцаанд хэрэглэх хүртэл гүнзгий ул мөр үлдээжээ. Харийн томоохон элчисийг ирэхэд мөн л дуу хуур болж хүлээн авч, ёсолж хүндэтгэж, үдэж мордуулж, төрийн хүлээн авалт уулзалт хийж, гэрээ хэлэлцээ байгуулж байжээ.

Мөнх хаан Франц улсад алтан пайз бүхий элчийг залахдаа цэрэг “очих орон, хот боомт зэр зэвсгийг нь сайтар тагнах” хэмээн зарлиг буулгаж байсан түүх бий. Монголын

⁴ Д.Гонгор, “Халх товчоон”, УБ 1978, 320 дахь талд

⁵ Ц.Дамдинсүрэн, “Монголын нууц товчоо”, УБ 1957, 236 дахь талд

⁶ Рашид-ад-Дин, “Судрын чуулган”, БИ, 117 дахь талд

эзэнт гүрний мандал, нэр хүндийг эрхэмлэж тэдний элчисийг найрсаг хүлээн авсан улс гүрнүүдэд нигүүлсэнгүй хандаж дайн тулалдаанд шууд дуудаж байсангүй.

Энэ тухай дээр дурьдсан Хорезмийн хаант улсад, Өмнөд хөршүүдэд, мөн Зүүн умард Ази, Солонгосын хойгт хийсэн байлдааны урьдал нөхцөл харуулдаг. Эе эвийг бодож дагаар орсон, итгэлийг эвдээгүй бол дайсанд ч найрсаг хандаж байсныг нотлох баримтууд ч олонтаа тохиолддог ажээ. Гүюг хаан Ромын Пап IV Инокентид явуулсан илгээлтдээ Папыг биеэрээ, ноёдоо дагуулан ирж хүндэтгэл үзүүлэхийг зөвлөж шаардсан гээд монголчууд өөрсдөд нь захирагдаагүй ямар ч улс үндэстнийг боол болгох тухай Плано Карпинигийн тэмдэглэлд байдаг. 1220 онд Монгол цэргийн жанжин Мухулай Хятадыг байлдан дагуулахад Хятадын генерал Ши Тан-Ин Монголд дагаар орсныг бодож өршөөгөөд зогсоогүй эзлэн авсан газар нутгийн энгийн номхон иргэдийг харгислан зовоосонгүй. Энэ бол нутгийн олны сэтгэлийг эзэмдэхийг чухалд үзсэн ба олзлогдогсдыг суллаж, дээрэм тонуул хийхгүй, дэг журамтай байх тушаал буулгасан нь үүний нэг баримт юм.⁷ 1225 онд Монголын хааны элч Чуку-юу Солонгост алагдсан учир 1231 онд дайн зарлаж Салидай жанжин ялалт байгуулж нийслэл нь Кангва аралд нүүж байжээ. Монголын байлдан дагуулалт, элчин харилцаа зөвхөн баруун зүгт чиглээгүй. Солонгосын хаанд залсан монгол элчийг Солонгост алагдсаныг буруушааж, “Хулганы зулзага шиг залихай Китан нар танай улсад халдахад та нар тэднийг тогтоож чадаагүй. Хэрэв бид тэрхүү залихай Китан нарыг хөөж гаргаж өгөөгүй болбоос та нар хожим болтол зовох байсан билээ”⁸ хэмээсэн нь Солонгосын хаад ч сүр хүчтэнийг аргадаж гэм буруу үйлдлээ “Таньж мэдээгүйгээр” элчийг хоргоож саатуулсан, амь насанд нь аюул учруулсандаа хүлцэл өгсөн баримт Солонгосын түүхийн хадгаламжинд цөөнгүй байдаг ажээ.

Монголын эзэнт гүрний үед цэрэг дипломатын арга, сүр хүчээ илтгэхийн зэрэгцээ дипломат ёс горим, харилцан хүндэтгэх эелдэг найрсаг хандлагын аль алиныг нь хэрэглэж байсан баримт цөөнгүй байдаг. Бага Азийн улсын эзэнд хүндэтгэл үзүүлж “...би наран ургах зүгийн, та наран жаргах зүгийн хүн зоныг захиран байна гээд эв найртай энх амгалан байж холбоо тогтооё”⁹ хэмээн эелдэг найрсгаар хандсан нь тус болоогүй.

Монголын эзэнт гүрэн, тэдний өмнөх эртний улс аймгуудын ёс заншилд үндэслэн улам бүр өргөжин, геополитик буюу зөвхөн Азиар барахгүй дэлхий дахинд ноёрхох тэлэх гадаад бодлого явуулж нэр нөлөө нь өссөн билээ. “Эзэнт гүрний үед монголчууд Ази,

⁷ Д.Оссон, “Монголчуудын түүх”, 1-р боть, 204 дэх талд

⁸ Б.Сумъяабаатар, “XIII-XIV зууны Монгол, Солонгосын харилцааны бичиг”, УБ 1978, 53 дахь тал

⁹ Paul Ratchnevsky, “Genghis Khan, His Life and Legacy ” London. 1991

Европын өргөн уудам нутагт өөрийн өвөрмөц соёлын ба гадаад бодлогын ул мөрийг үлдээсэн билээ”¹⁰

Нэрт Монгол судлаач Паул Рачневский, “Чингис хааны дэлхийг ноёрхох эрмэлзлэл дээд тэнгэрийн тааллын сурвалжтай хэмээх итгэл үнэмшлээс үүдэлтэй гээд монголчуудын давуу талыг бусад аймаг, үндэстнүүдээр хүлээн зөвшөөрүүлэх явдал гадаад бодлогын нь тулгын чулуу байсан юм.”¹¹ гэж онцлон тэмдэглэжээ.

Монголын эзэнт гүрэн өрнө, дорнын соёл, худалдааны болон улс хоорондын харилцаанд ихээхэн нөлөө үзүүлж чадсаныг дэлхийн түүхэнд Монголын эрин хэмээн тэмдэглэгдсэн нь эдүгээ хүртэл монголчуудын үндэсний бахархал болон үлджээ. Ер нь Монголын эзэнт гүрний гадаад цэрэг, улс төрийн бодлогыг бүхэлд нь хуучин үе шиг харлуулан эсвэл бүхэлд нь хэт магтан дэвэргэлгүй түүхэн тодорхой нөхцөлтэй уялдаатайгаар бодитой авч үзэх нь зохистой байна.

Эзэн хааны элчис нууцыг чандлан сахих, хаант улсын төрд үнэнч байх, урван тэрслэх, шан харамжинд хууртах явдлыг тэвчдэггүй байсан түүхтэй юм. Ер нь андгай тангаргаас няцах аваас хамгийн хатуу цээрлүүлдэг байв. Дипломат ёс горим аль ч үндэсний уламжлал ёс заншилтай уялдаатай байдаг. Нөгөөтэйгүүр түүхэн нөхцөлд гадаад, дотоод орчин тухайн улс үндэстний мандал, бууралттай холбоотойгоор авч үзэх учиртай юм.

Нэгэн үе Оросын хаад, вангуудад мөн Юан гүрний үед хятадуудад өөрийн төрт ёсны нөлөө үзүүлж ноёлж байсан монголчууд Манжийн ноёрхолд орж гадаад ертөнцөөс тусгаарлагдан байснаа 1911 оноос үндэсний ухамсар нь сэргэж туурга тусгаар улсаан бэхжүүлэхэд эх орончдын маань ачаар гал голомт тасралтгүй явсаар хутганы ирэн дээрх тусгаар тогтнол сайн муу олныг үзсэн түүхтэй.

Дипломатын түүх, ёс горимд улсынхаа эрх ашгийг хамгаалах, төлөөлөх ёс эртнээс улбаатай ажээ. Энэ тухай “Монголын хаад төрийн гадаад харилцаандаа өөрийн чадварлаг хүмүүсээс гадна харийн соёл, хэл, хэв заншил, ёс суртахуун, дүрэм горим, газар нутгийг сайн мэдэх гаднын хүмүүсийг авч хэрэглэхийг чармайдаг байжээ”¹²

Хар Хорум нийслэлтэй эзэнт гүрэн, мөн түүний дараах Юан гүрний үед алс холын Европ, Дундад болон Умард, Өмнөд Азиас олон орны элчис их хаадад бараалхаж байсан ба гадаад гүрний төр, шашны тэргүүн нартай захидлаар харилцан бэлэг сэлт солилцож байсан

¹⁰ “Монгол улсын түүх”, УБ 1999, 388 дахь талд

¹¹ Paul Ratchnevsky, “Genghis Khan, His Life and Legacy” London. 1991, p.159

¹² Д.Хүүхэнбаатар, “Монгол гүрний элчин харилцаа”, УБ 1964 он, 13 дахь тал

тухай түүхчид, элчисийн тэмдэглэл цөөнгүй байна. Харийн шашныг хүндэтгэх, төрийн хэрэгт шашныг ашиглах, итгэн сүсэглэх явдал ч дэлгэрч байв. Худ ураг бололцож, харь гүрнүүдтэй холбоо тогтоож дайснуудтай хүч хавсран тэмцэж, нөлөө сүр хүчээ нэмэгдүүлэх олон арга хэрэгслийг ашиглаж байсан юм.

Ромын Пап ламтан IV Инокентэй 1245 онд монголчуудын цэргийн төлөвлөгөөг мэдэх зорилгоор католик шашны зүтгэлтэн Плано Карпинийг, бас бус элчийг Монгол руу залж байсан түүх, мөн Гүюг хааныг ширээнд өргөмжлөхөд гаднын улс орнуудаас 4000 гаруй элч ирж байсан зэрэг нь тэр үед Монголын эзэнт гүрэн, түүний нийслэл гадаад улсуудын анхаарлыг хэр зэрэг татаж байсныг нотлох баримт мөн.

Өгөөдэй хаан ууган хүүгээ хаан болгох санаатай байсан ч Дөргөн хатан Гүюгийг хаан ширээнд залж гаргахаар Турк, Багдадын Халиф, Гүрж, Александр Невскийн эцэг, хаан хүү II Ярослав зэрэг өндөр зочдыг урьж, 1246 оны 7-р сарын 22-нд 65 настай Плано Карпини тагнан туршихаар ирсэн байдаг. Монголын хаан Ромын Папын илгээлтийн жинхэнэ санааг мэдэлгүй, тэд их хаанд захирагдах болсон хэмээн эндүүрч байжээ. Энэ тухай Америкийн судлаач Жак Уэдэрфордын бүтээлд дэлгэрэнгүй бичжээ.¹³

1246 онд Монгол улсын Эзэн хаан Гүюг Европын Пап ламд явуулсан илгээлт бичигт: “Мөнх тэнгэрийн хүчин дор Их Монгол улсын далай Их хааны зарлиг эл болгон иргэн дор хүрвээс, биширтүгэй, айтугай”¹⁴ хэмээжээ. Чингис хааны ба түүний дараачийн хаадын үед иймэрхүү үг үсэгтэй алт, мөнгөн пайзыг элчид олгож хүзүүнээс зүүж, өвөртлүүлж гадаад гүрэнд илгээвээс түүнийг хэн ч барьж саатуулах эрхгүй (дархан эрхтэй Д. Ц.) гэсэн агуулгатай жуух бичгийн нэгэн хувилбар гэж үзэж болно.

Төрт ёсны уламжлалыг хадгалж, зочин элчийг угтах, үдэх, тэгэхдээ тэдний зэрэг дэвийг харгалзан хүндэтгэл үзүүлэх ёс горимыг маш нарийн баримталж байсан тухай “Халх журам”, “Гадаад Монголын төрийг засах явдлын Яамны хууль зүйн бичиг” (1789), “Монгол Ойрадын цаазын бичиг” (1640) зэрэгт нарийн өгүүлсэн байдаг. Энэ бүхэн нь нүүдлийн мал аж ахуй бүхий монголчуудын зан үйл, төрт ёсны уламжлал Манжийн ноёрхлын үед ч бүрэн устаагүйг гэрчилдэг юм.

Хааны элч сайдыг ирэхэд “Харъяат ван, бэйл, бэйс нар таван газрын адагт угтаж олноор мориноос буун сөгдөж угтана” гэх буюу хас тамга бүхий бичигтэй сайдыг илгээж, чуулган эхлэхэд суудлыг хуваарилах, “Зүүн этгээдээс баруун этгээдийг хандан зогсох”, харилцан мэхийн мөргөж ёслох, сөгдөж зарлигийг хүлээн авах зэргийг нарийн заасан

¹³ Jack Weatherford “Genghis Khan and The Making of The Modern World” NY, 2004, p. 162

¹⁴ Ц.Дамдинсүрэн, “Монголын уран зохиолын дээж”, ОМ-ын Ардын хэвлэлийн хороо, 1957. 52-53 дахь тал

байдаг.¹⁵ Харин Монгол Ойрадын цаазын бичигт энэхүү ёс горим шарын шашны мөргөлийн агуулгатай болсон тухайн үеийн утга санааг илтгэдэг ажээ. Гэхдээ “Төр улсын тусгаар тогтнолыг эргүүлэн авах, гэмт муу үйлдлийг арилгах зэрэг ард түмний оюун санааны эрхэм бүгдийг шингээн хамруулан өгүүлсэн нь шүлгийн гол цөм болно”¹⁶ гэж тэмдэглэсэн байна. Элчис унах унаа, шүүс хэрэглэх, өөрийн бараа бологсдыг дагуулан явах зэргийг нарийн зааж өгсөн байдаг ажээ.

Монголчууд тусгаар тогтнолоо зарласан Богд хаант Монгол улсын үед Манжийн хуулийг хэрэглэхийг зогсоосон үеийн хууль зүй төрт ёсны чухал баримт бичиг “Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг”-т¹⁷ тусгаар улсын шинжийг агуулсан, шашин төрийн эрх ямбыг илтгэсэн байна. Үүнд:

Бат оршил өргөх, хаан их дагинын түмэн өлзий гийсэн өдөр, түүнчлэн цагаалах, шинэлэх, мөргөх тухай ёс горимыг нарийн гаргасан байдаг. Сайд, түшмэд, лам хутагт хувилгаан нар мөргөх газарт хүрсний хойно, үг хэлэлцэх, ханиах зэрэг дуу чимээ гаргах бус тийш юм үзэх зэргээс хэтэрч шахцалдан тэмцвээс болохгүй. Сөгдөн мөргөхөд алгуурхан бөгөөд толгойг доор бөхийж хичээнгүйлэн Богд эзэн, улсын эх дагинын гэгээнд тус тус гурвантаа сөгдөж, дээдэстээ мөргөсний хойно шавийн ёсоор хадаг өргөгтүн. Хэрэв ёсыг алдваас удирдах түшмэл байцаан гаргаж буруушаан ял хэлэлцэгтүн¹⁸. Нэгэнт биеэ даасан улс болохыг зарласан үеэс “Аливаа хэргийн учир зарлигаар сайд гаргах ёслолыг явуулахад гадаад улс лугаа харилцан гэрээ бичиг тогтоох зэрэг улс төрийн ихээхэн хэргээр илгээх бүрэн эрх барих сайд, жич дайлаар одох, эвлэн засах, их жанжин сайдыг гаргах нь болбоос зарлиг буулгасны хойно Дотоод яаманд тушааж жуух тамгыг үйлдүүл” гээд өдөр судрыг товлох, цайны асар бэлтгүүлэх, жуух тамгыг өргөн харъяат сайдад тушаан өгөхөд сөгдсөөр хүлээн аваад дагалдах түшмэдэд уламжлан тушаан өгнө.

Цай барьж үдэн мордуулаад буцан ирэхэд нь мөн адил хүндэтгэл үзүүлэн ёслох тухай заасан байна. Золгох ёслолын тухайд зочид ороход гэрийн эзэн дагалдан орж, буцахад хаалганы гадна үдэж харилцан мэхийн ёслоод зочдыг тэргэнд суусны хойно гэрийн эзэн эзэгтэй гэртээ морилно. Гаднаас ирэх элчийн тухай Сангийн яаманд мэдэгдэж гэр, хэрэглэх зүйлийг бэлтгэж төрийн ордонд орох гарахад газарчилж, хэлмэрч түшмэлийг бэлтгэх тухай ч нарийн заасан байдаг. Албан харилцааны бичигт маш няхуур

¹⁵ Б.Баярсайхан, “Монгол цаазын бичиг”, УБ 2001, 41 дэх тал

¹⁶ Мөн тэнд 48 дахь тал

¹⁷ Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг”, УБ 1995

¹⁸ Мөн тэнд, 104-106 дахь тал

хандаж түүнийг өртөөнд хүлээн авах, дамжуулах наалдуулах (дагалдах хуудас Д.Ц) хуудас үйлдэж яаралтай дамжуулах тухай заагаад саатуулан, урж наасан бол ял хэлэлцэж байхаар заажээ. Мөн элчин консулаас дээш түшмэл Хүрээн ирэх бол хязгаарт (хилээр) орж ирсний хойно замд тохиолдох газар орны сайд, түшмэл сайхнаар хамгаалан өнгөрүүл¹⁹ гэсэн нь халдашгүй дархан эрхийн тухай өгүүлсэн байна. Мөн зочдыг угтах цайны асар бэлтгэх, Гадаад яамны дэд сайд, Дотоод яамны ёслолын түшмэл, Сангийн яамны дэс түшмэл угтан аваад үйлчлэх, унаа нь алжаасан бол сольж өгөх, цахилгаан тэрэг хэрэглэсэн бол түүнийг шагнах зэрэг ёс горимыг маш нарийн зааж байжээ. Энд дурдсан ёс горим, ёслолын холбогдолтой жишээнүүд Манжийн үе, Богд хаант Монгол улсын төрийн ёс жаягтай холбоотой байна.

Тусгаар тогтнолоо зарласан 1921 оноос дипломат ёс горим, ёслолын элементүүдийг ЗХУ-ын ном зааврыг баримтлан хэрэгжүүлж байв. Орчин үеийн дипломат ёслол, ёс горимын эх сурвалж нь сонгодог дипломат ёслол бүхий Франц, Англиас Европ дахинд нэвтэрч, тэр нь Оросоор дамжин Монголын шинэ үеийн гадаад албаны үйл ажиллагаанд нэвтэрсэн гэж үзэх бүрэн үндэслэлтэй юм. Шинэ Монголын дипломат ёс горим, олон улсын эрх зүйн хэм хэмжээ, ёслолын ёс горимтой уялдаатайгаар нарийсан өөрчлөгдөж ирсэн юм. Монголын тусгаар тогтнолыг бүрэн утгаар нь дэлхий дахин хүлээн зөвшөөрсөн үйл явцтай ялангуяа НҮБ-д гишүүнээр элссэн үеэс хойш гадаад харилцаа өргөжиж, дипломат ёслолын үйл ажиллагааны цар хүрээ, агуулга хэлбэрийн хувьд баяжсан юм. Төрийн ёслол, дипломат ёс горимд гарсан өөрчлөлт их байгаа боловч түнийг боловсронгуй болгох, дагаж мөрдөх асуудал чухал юм. Монгол төрийн ёслолын 2000 онд батлагдсан журам нь бусад улс гүрнүүдийн нэгэн адил уламжлал, үндэсний онцлог, нийтээр дагаж мөрдөж байгаа нь ёс журмын жишгийг баримталсан байна. Ёс горим ёслолын агуулга, хэлбэрт анхаарч ач холбогдлыг нь ухаарч түүнд үндэсний эрх ашиг, нэр хүндийг бодон нэгдмэл байр сууринаас хандах нь төрийн өндөрлөгүүдээс аваад, төрийн түшээд, гадаадад суугаа ДТГ-ын ажилтнуудын эрхэм үүрэг байх ёстой. Энэ тухай зохиогч “Гадаад бодлого, дипломат ажиллагааны залгамж, нэгдмэл чанарын тухай өгүүлэх нь” хэмээх өгүүлэлдээ (“Алтан аргамж сэтгүүл” УБ 2001) тодорхой өгүүлсэн билээ.

Үндэсний болон дипломат ёслолын аливаа арга хэмжээг зохион байгуулах, өндөр хэмжээний төлөөлөгчдийг хүлээн авах, угтах, тэдэнд хүндэтгэл үзүүлэх, төрийн тэргүүн,

¹⁹ Мөн тэнд 111 дэх тал

түүний гэргийн хувцаслалт, зоог бэлдэх зэрэг олон асуудлаар шинэчлэн өөрчллөгдсөн зүйлс багагүй байгаа юм. Төрийн албаны зарим хэсгийн ёслолын хувцас Манжийн түшмэдийн үеийг санагдуулахаар байгаа юм. Үүнд би Үндсэн хуулийн цэцийн гишүүдийн малгайн тухай онцлон дурдмаар байна. Гадаадын өндөр хэмжээний төлөөлөгчдийг угтах ёслолын горим ч тэдэнд барих зоог, үйлчилгээний дэг жаяг жигдрээгүй мэт санагддаг. Нэг үе Сүхбаатарын талбайд, заримдаа төрийн ордны коридорт (гудамд) угтан авч хүндэтгэж байв. Гадаадын дипломат төлөөлөгчийн газрын тэргүүний итгэмжлэх жуух бичгийг бариулахаар угтан авахдаа өмнө нь Төрийн ордны урд талын талбайд авч байснаа эдүгээ ордны хойд талд хүндэт харуул, үлээвэр найрал хөгжимтэй зогсч байна.

Өндөр дээд хэмжээний төлөөлөгчдийг хүндэтгэн барих зоогт тарган хонины ууц тавьж, царцуу өөх өгөхөд гадаадынхан төдий л таашаадаггүй мэт санагддаг. Сайд дарга нар ч гадаадад, эсвэл гадны зочинтой уулзалт яриа хийхдээ сайн бэлтгэж, сэтгэлийн хөөрлөөр хандахгүйгээр Монгол улсын төр, засгийн газрыг төлөөлж буйгаа ухаарч ая дантай хандаж сурах шаардлагатай байгаа юм.

Төрийн түшээ эмэгтэйчүүд, тэргүүн хатагтай нар хүндэтгэл ёслолын арга хэмжээнд оролцохдоо дээл хувцсаа тааруулж, биеэ соёлтой авч явмаар санагддаг. Их Монгол улсын 800 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэхдээ бодитой ажил хийж, аль болохоор хөрөнгө хий үрж шоудахгүйгээр бодитой, Монголын түүх соёлын өв сангаа аливжуулахад чиглэсэн, ард олны таашаалд нийцсэн бүх нийтийн арга хэмжээнүүд зохиогдоно байх гэдэгт найдаж байна.